

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

**УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**



**НЭН ТЭРГҮҮНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ДЭД ТӨСЛҮҮДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ САНХҮҮЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

2013 ОНЫ 6 ДУГААР САР

Агуулга

Тайланг бэлтгэсэн:
ҮАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын газар

Захирал *Б.Баттуяа*

Аудитын
менежер *Г.Гүнжидмаа*

Аудитор *Ш.Энхтайван*

Шинжээч *М.Доржмаа*
Ж.Оюунтуяа

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 261885, 263755, 261805
дугаарын утас, 323266
дугаарын факсаар харилцана уу
ХАЯГ:

Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

Агуулга 2

Товчилсон үгийн жагсаалт 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
стандартын талаарх мэдэгдэл 4

Ерөнхий зүйл 5

**Бүлэг 1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага,
удирдах хороо, нэгжийн үйл ажиллагаа**

Төслийн удирдах хороог гэрээний нөхцөлийн
дагуу байгуулаагүйгээс дахин шинэчилжээ 7

Төслийн удирдах хорооны хяналт сулаас үргүй
зардал гарч, дотоод үйл ажиллагаа суларч байна 7

Бүлэг 2 Төслийн хэрэгжилт, үр дүн 9

Удирдах хорооны шийдвэрийг зөрчиж зарим
албан тушаалтныг сургалтад хамруулжээ 9

Засгийн газрын мөрийн хөтөлбөр, хөрөнгө
оруулалтын бодлоготой төслийн үйл ажиллагааг
зохицуулаагүйгээс 4 дэд төсөлд хийсэн ажлын
даалгавар үр дүнгүй болжээ 9

Дүгнэлт

Зөвлөмж

Хавсралт

Товчилсон үгийн жагсаалт

АМГ	Ашигт малтмалын газар
АХБ	Азийн хөгжлийн банк
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГЗТЗТХ	Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хууль
ЗТБЗГ	Зээл тусламжийн бодлого зохицуулалтын газар
ЗТЭ	Зээлжих тусгай эрх
ОУХА	Олон улсын хөгжлийн ассоциаци
СХОГ	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
СЯ	Сангийн Яам
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТУХ	Төслийн удирдах хороо
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УИХ	Улсын Их Хурал
УУДБХОДТ	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл
УУИБТТТ	Уул уурхайн институцийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл
УУЯ	Уул уурхайн яам
УҮХ	Усны үндэсний хүрээлэн
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЦЭГ	Цөмийн энергийн газар
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн үйл ажиллагааны үр дүн, зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийж үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаа хэлэлцээрийн дагуу хэрэгжсэн эсэх
- Төслийг хэрэгжүүлснээр бодит үр дүн гарсан эсэх

Хамарсан хүрээ

Аудитад Сангийн яам, Уул уурхайн яам, Эрчим хүчний яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Төрийн өмчийн хороо, “Эрдэнэс МГЛ” ХХК, төсөл хэрэгжүүлэх нэгж болон холбогдох бусад байгууллага хамрагдлаа.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын дараах арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Холбогдох албан тушаалтантай ярилцаж, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл гаргуулан судалгаа хийх, төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлэх
- Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий зүйл

1.1 Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан Дэлхийн Банкны 16,000.0 мянган зээлжих тусгай эрхийн зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн хэлэлцээрийг УИХ 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдөр соёрхон баталсан байна.

1.2 Төсөл 2011 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 2016 оны 9 дүгээр сарын 31 хүртэл хугацаанд хэрэгжих бөгөөд Монгол орны өмнөд говийн бүсийн усны сав газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, хяналт шинжилгээний сүлжээг байгуулах, гүний усны түвшний судалгаа хийх, шинээр хайгуул, шинжилгээ, явуулахаас гадна усыг зохистой хэрэглэх, тогтвортой хуваарилах журам, заавар боловсруулж уул уурхайн салбарын дэд бүтцийг дэмжихэд төслийн зорилт чиглэгдсэн байна.

1.3 2012-2013 онд нийт 2,896.4 мянган ам.доллар (1933.5 мянган ЗТЭ буюу нийт санхүүжилтийн 12.08 хувь)-ын санхүүжилтийг Худалдаа Хөгжлийн банк дахь төслийн санхүүжилтийн дансаар дамжуулан ОУХА-аас хүлээн авсан бөгөөд дараах ангиллын дагуу 555,0 мянган ам.долларыг зарцуулжээ.

	Үзүүлэлт	2012	2013	/мянган ам.доллараар/ Нийт санхүүжилт
	ОУХА-ийн санхүүжилт	2,896.4	135.7	3,032.1
	Төслийн зарцуулалт	482.7	72.4	555.0
	Санхүүжилтийн үлдэгдэл	2,413.7	63.4	2,477.1

1.4 Төслийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2013 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар үзүүлбэл:

		/мянган ам.доллараар/					
№	Үйл ажиллагаа	Нийт төлөвлөгөө	2012 оны гүйцэтгэл	2013 оны I улирлын гүйцэтгэл	Нийт гүйцэтгэл	Үлдэгдэл	
1	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт	18,750.0	122.6	37.9	160.5	18,589.5	
2	Чадавхийг бэхжүүлэх	1,385.0	132.5	0.00	132.5	1,252.5	
3	Гүний усны удирдлага	3,075.0	0.00	0.00	0.00	3,075.00	
4	Төслийн удирдлага	852.0	227.6	34.4	261.9	590.0	
5	Бусад зардал	1,190.0	0.00	0.00	0.00	1,190.0	
	Нийт	25,252.0	482.7	72.4	555.0	24,696.9	

1.5 2013 оны эхний улирал хүртлэх хугацаанд нийт зарцуулалтын 47.2 хувийг төслийн удирдлагын (төсөл хэрэгжүүлэх нэгжийн) зардалд, 28.9 хувийг дэд

төслүүдийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар боловсруулах ажилд, 23.9 хувийг чадавхийг бэхжүүлэх буюу сургалт, танилцах аялал, хурал, семинарт зарцуулсан байна.

- 1.6 Төсөл хэрэгжих хугацааны 25 хувь өнгөрсөн байхад төслийн удирдлагын зардлын 30.7 хувь (төслийн тоног төхөөрөмж худалдан авалтыг оролцуулан), дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр 0.9 хувь, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр 9.6 хувийг тус тус зарцуулсан байна.
- 1.7 Төслийн удирдлагын зардал төлөвлөсөн хэмжээнээс хэтэрсэн, бусад зүйл дээр төлөвлөгөөнөөс хоцорч, сайн гүйцэтгэлтэй гэж үзсэн ажлын зардал 9.6 хувь байгаа нь хангалтгүй байна
- 1.8 Хэлэлцээрийн 2 дахь хэсэг болох “Гүний усны менежментийг бэхжүүлэх” бүрэлдэхүүн хэсэг Австралийн олон улсын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжаар хэрэгжих бөгөөд “Монголын өмнөд бүсийн дэд бүтцийн стратеги”-тэй уялдуулан хэрэгжүүлэхээр болжээ.

Бүлэг 1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, удирдах хороо, нэгжийн үйл ажиллагаа

Төслийн удирдах хороог гэрээний нөхцөлийн дагуу байгуулаагүйгээс дахин шинэчилжээ

- 2.1 Төслийн санхүүжилтийн гэрээ ёсоор төслийн удирдах хороо нь төслийн хөрөнгийн ашиглалтыг удирдамжаар хангах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, салбар хоорондын нөлөөлөл бүхий дэд бүтцийн төслүүдийг боловсруулахад холбогдох яам, агентлагийн санал авах, оролцоо, хамтын ажиллагааг хангах, ажлыг бодлогын чанартай удирдамжаар хангах үүрэг хүлээсэн байна.
- 2.2 Дээрх үүргийг хангахын тулд хэлэлцээрт удирдах хороог Сангийн яамны ТНБД-аар ахлуулан Сангийн яам, ЭБЭХЯ, ЗТБХБЯ /хуучнаар/, БОАЖЯ /хуучнаар/ ҮХШХ /хуучнаар/, ТӨХ болон УҮХ-ын төлөөллөөс бүрдүүлэхээр тусгажээ.
- 2.3 Сангийн сайдын 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн тушаалаар байгуулсан төслийн удирдах хороог 14 гишүүнтэйгээр, Сангийн сайдын 2013 оны 34 дүгээр тушаалаар 15 гишүүнтэйгээр тус тус баталсан байна.
- 2.4 “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төсөл хэрэгжүүлэх нэгж 2011 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр байгуулагдсанаас хойш 3 сарын дараа нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг төслийн удирдах хороогоор батлуулсан байна.

Төслийн удирдах хорооны хяналт сулаас үргүй зардал гарч, дотоод үйл ажиллагаа суларч байна

- 2.5 Тус төслийн үйл ажиллагаа удаашралтайгаас үр ашиггүй зардал гарч байна.

Тухайлбал: 7 ажилтантай төсөл байрны түрээсийн зардалд сард 895.2 мянган төгрөг зарцуулж байхад 5 ажилтантай уг төсөл сар бүр 2.7 сая төгрөг зарцуулж байна.

№	Төслийн нэр	Ажилтны тоо	Талбай	Нэгж талбайн хөлс /төг/	Нийт талбайн хөлс /мян.төг/
1	УУДБХОДТ	5	95.00	28,000	2,660.0
2	УУИБТТТ	7	68.86	13,000	895.2

- 2.6 Төслийн санхүүгийн ажилтанг Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар баталсан журамд зааснаар 6 сарын хугацаагаар түр томилоогүйгээс санхүүгийн баримт материал, тайлан мэдээг тухайн ондоо үдэж архивлаагүй, хадгалалт хамгаалалт хангалтгүй, задгай эмх цэгцгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 20.3-ын “Холбогдох байгууллага, албан тушаалтан төсвийн мэдээллийн тогтолцоонд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн

баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна.

- 2.7 Төслийн зохицуулагч нь журмын 3.1.12-т “...зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтыг гүйцэтгэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтыг хөтлөх, төслийн явцыг шууд тайлагнаж, холбогдох шийдвэрийг гаргуулах үүрэг бүхий ...” гэж заасныг зөрчиж томилолтын тайлан, мэдээг бүрдүүлээгүй байна.
- 2.8 Тухайлбал Орхон аймаг, Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр, Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай, Шүрэнгийн цахилгаан станц зэрэг газруудад нийт 3181 ам.долларын зардал гаргаж томилолтоор ажилласан боловч ажлын тайланг Сангийн яаманд танилцуулаагүй байна.

Бүлэг 2. Төслийн хэрэгжилт, үр дүн

Удирдах хорооны шийдвэрийг зөрчиж зарим газрын албан тушаалтныг сургалтад хамруулжээ

- 3.1 “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслөөс 2012 онд 132.5 мянган ам.долларыг гадаад, дотоодын сургалт семинарт зарцуулсан байна.
- 3.2 Төслийн удирдах хорооны 2012 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар Төмөр замын газрын болон хувийн компанийн хүмүүсийн сургалтын зардлыг төслөөс санхүүжүүлэхгүйгээр шийдвэрлэсэн боловч Төмөр замын газрын дэд дарга Л. Пүрэвбаатарыг ОХУ, Канад улсад 2 удаа, техник технологийн хэлтсийн дарга Д.Мандахбаярыг Канад улсад 1 удаа, нийт 2,495 ам.долларын сургалтад хамруулсан байна.
- 3.3 “Компанийн засаглалын тухай” хуулийн 75.8-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна” гэж заасныг үндэслэн Төрийн өмчийн хороо ТӨХК-ны 25 хүнийг дотоодын сургалтад хамруулах саналыг төслийн удирдах хорооны 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлэснээр 20 хүнийг хамруулан нийт 11.4 сая төгрөг зарцуулсан байна.
- 3.4 Компанийн засаглалыг сайжруулах сургалтыг зайлшгүй хэрэгцээтэй сургалт гэж үзсэн боловч сургалтын хөтөлбөрөөс харахад төслийн зорилттой хамааралгүй сэдвээр зохион байгуулагдсан байна.
- 3.5 Дээрх сургалтад авто замын засвар арчилалтын компаниуд, МИАТ, Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор, Хөтөлийн цемент шохойн үйлдвэр, Хөдөө аж ахуйн бирж зэрэг байгууллагуудын гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар хамрагджээ.

Засгийн газрын мөрийн хөтөлбөр, хөрөнгө оруулалтын бодлоготой үйл ажиллагаагаа зохицуулаагүйгээс 4 төсөлд хийсэн ажлын даалгавар үр дүнгүй болжээ

- 3.6 Төслийн хүрээнд дэд төслүүдтэй холбогдох яамд, агентлагуудын хийсэн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчилж нарийвчлан боловсруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, хэлэлцээр байгуулах, гэрээний биелэлтийг хангах, хэрэгжилтийг үнэлэх, хяналт шинжилгээ явуулах чадавхийг бэхжүүлэх зэрэг ажлыг хийхээр төлөвлөсөн байна.
- 3.7 “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалт”-ыг дэмжих төсөлд Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, /хуучнаар/, Мэдээлэл, шуудан харилцаа холбооны технологийн газар /хуучнаар/, холбогдох бусад яам агентлагуудаас нийт 48 дэд төслийн санал ирүүлжээ.

3.8 Дээрх төслүүдийг төслийн удирдах хорооны хурлаар хэлэлцэж дараах нэр бүхий 6 дэд төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

- “Орхон гол дээр урсацын тохируулга хийх, усан сан байгуулах” төслийн ТЭЗҮ боловсруулах төсөл
- Дархан-Сэлэнгийн төвийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах
- “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 2 дахь шатанд барих Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ боловсруулах
- “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3 дахь шатанд барих төмөр замын урьдчилсан ТЭЗҮ боловсруулах
- Шүрэнгийн усан цахилгаан станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах
- “Эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортыг хөнгөвчлөх томоохон уурхай, хилийн боомтыг хамарсан цогц удирдлага, хяналтын систем”-ийн ТЭЗҮ боловсруулах

3.9 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг холбогдох яам, газруудын төлөөллийг оролцуулан байгуулж, тус ажлын хэсэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх гадаад, дотоодын зөвлөхүүдийг шалгаруулжээ.

3.10 Дээрх төслүүдийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар боловсруулах ажлын зөвлөх сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер явуулж дор дурдсан байгууллага, иргэнийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна. Үүнд:

Төслийн нэр	Хийх ажил	Сонгогдсон зөвлөх	Гэрээний дүн /ам.дол/
“Орхон говь” төслийн ТЭЗҮ хийх	Ажлын хэсэгт техникийн туслалцаа үзүүлэх бие даасан зөвлөхүүдийг сонгох	Евгений Симонов-ОУ-ынбие даасан зөвлөх Л.Өлзийжаргал-Дотоодын бие даасан зөвлөх	24,725.44
Төмөр замын тээврийн талаарх бодлогын 2 болон 3 дахь үе шатанд шинээр барих төмөр зам төсөл		Даниел Месник-ОУ-ын бие даасан зөвлөх Д.Готов-дотоодын бие даасан зөвлөх	46,912.19
Өндөр хурдны өргөн зурвасын цогц сүлжээ байгуулах, цогц удирдлага, хяналтын систем хөгжүүлэх төсөл		Роналд Бокс- Олон улсын бие даасан зөвлөх Д.Энхцог- Дотоодын бие заасан зөвлөх	21,079.38
Дархан-Сэлэнгийн төвийн бүсэд Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл		Йорг Оверлаендар- ОУын бие даасан зөвлөх Я.Дашдондог- Дотоодын бие заасан зөвлөх	34,530.18
Шүрэнгийн УЦС төслийн ТЭЗҮ боловсруулах төсөл		Брайн Лэйланд- ОУ-ынбие даасан зөвлөх Б.Болдбаатар- Дотоодын бие заасан зөвлөх	33,280.85
Нийт			160,528.04

3.11 Нийт 160.5 мянган ам.долларын зардлаар 6 дэд төслийн ажлын даалгавар боловсруулагдсан боловч 2 төслийн ТЭЗҮ боловсруулах ажлыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр, 2 төслийг холбогдох яаманд шилжүүлэхээр, 2 төслийг ТУЗ-өөр хэлэлцэж байна.

3.12 БОАЖЯ /хуучнаар/, ҮХШХ-оос /хуучнаар/ ирүүлсэн Орхон гол дээр урсацын тохируулга хийх, усан цогцолбор байгуулж говийн өмнөд бүс нутгийн усны хэрэгцээг тодорхой хэмжээгээр хангах “Орхон-Говь” төслийг сонгосон байна.

3.13 Мөн Дархан-Сэлэнгийн төвийн бүсэд Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төслийг сонгосон ба төслийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр эхний үе

шатанд ажлын даалгавар боловсруулах, 2 дахь үе шатанд технологийн сонголт хийж сүүлийн шатанд сонгон авсан технологид суурилан ТЭЗҮ боловсруулахаар төлөвлөсөн байна.

- 3.14 Одоогоор ажлын даалгавар боловсруулагдсан ба 2 дахь шатны ажил болох технологи сонгох, лабораториар сорьц тогтоолгох ажил хийгдэж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, шинжилгээний дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- ✚ Төсөл хэрэгжих хугацааны 25.0 хувь өнгөрсөн бөгөөд төслийн удирдлагын зардлаас бусад төлөвлөсөн арга хэмжээний зардал 0.9-9.6 хувийн гүйцэтгэлтэй байна.
- ✚ Төсөл хэрэгжүүлэх нэгжийн орон тооны бүтцийг журмын дагуу батлаагүй, батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаагаа санхүүжүүлээгүй байна.
- ✚ Төслийн зорилт, ТУХ-ны шийдвэрээс гадуур сургалт зохион байгуулсан, сургалтад оролцогчдыг санхүүжүүлсэн байна.
- ✚ 6 дэд төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг гадаад, дотоодын зөвлөхүүдээр ихээхэн хөрөнгө зарцуулж боловсруулуулсан боловч цаашид зөвхөн 2 дэд төслийн ТЭЗҮ боловсруулах ажлыг төслийн шугамаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, 2 төслийг холбогдох яаманд шилжүүлж, 2 төслийг хэрхэх нь тодорхойгүй байна.
- ✚ Монгол Улсын Засгийн Газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хоорондын гэрээ болон Сангийн сайдын 2011 оны 86 дугаар журмыг хэрэгжүүлээгүй байна.

Сангийн яамнаас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2013.10.01 № 4-2/5443
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Б.БАТБАЯР
ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны саналаар “Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл”, “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авлаа.

Тайлангийн төсөлтэй танилцаж, холбогдох заалтуудад хийх нэмэлт тайлбар, аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн авах арга хэмжээний зөвлөмжид оруулах саналуудыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 32 хуудастай.

САЙД



Ч.УЛААН

п 3807

ҮАГ-ын тайлбар
1-ийг үзнэ үү.

ХОЁР. УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ТАЙЛБАР, САНАЛ

1.5, 1.6, 1.7 Үйл ажиллагааны аудитад хамрагдсан хугацаанд нийт 555,0 мянган ам.долларын зээлийн хөрөнгө ашигласнаас 47.2 хувийг төслийн удирдлагын /төсөл хэрэгжүүлэх нэгжийн/ зардалд зарцуулсан гэсэн дүгнэлт гаргасан байна. Дээрх 47.2* хувийн хөрөнгийн зарцуулалтын тайланг Хүснэгт А-аас харна уу.

Бүрэлдэхүүн хэсэг 4: Төслийн удирдлага

зардал	2012	2013/01 ул	Нийт	Хүснэгт А /мянган ам.доллараар/		
				Зөвшөөрөгдөх	Гүйцэтгэл	-
4.1 Зөвлөх үйлчилгээ			424.0	97.1	22.4	119.5
4.2 ТХН-ийн оффисын тавилга, тоног төхөөрөмж			38.0	23.7	-	23.7
4.3 ТХН-ийн хэрэгцээний автомашин			75.0	49.9	-	49.9
4.4 ТХН-ийн үйл ажиллагааны зардал			63.0	56.9	11.9	68.8
<i>/жилийн дундаж/</i>						
НИЙТ ДҮН			25,000.0	227.6	34.3	261.9*

Төслийн удирдлагын зардал болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардал нь өөр хоорондоо ялгаатай ойлголт бөгөөд төслийн удирдлагын зардалд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зөвлөхүүдийн ажлын хөлс, тоног төхөөрөмж, төслийн үйл ажиллагааны зардал багтдаг болно.

Хүснэгтээс зөвхөн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардалд нийт зарцуулсан зээлийн хөрөнгийн 11.5 хувь буюу 68.8 мянган ам.долларыг зарцуулсан болохыг харж болно. Түүнчлэн 2012 оны үйл ажиллагааны зардал нь батлагдсан үйл ажиллагааны зардлын жилийн дундаж төсөв болох 63.0 мянган ам.доллараас бага буюу 56.9 мянган ам.долларын гүйцэтгэлтэй байна.

Оффисын тоног төхөөрөмж, автомашин худалдан авах зэрэг зардлууд нь ТХН-ийг шинээр байгуулсантай холбогдуулан нэг удаа гарсан зардал болно. Харин ТХН-ийн ажилтнууд/зөвлөхүүдийн цалинг Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Төслийн удирдах хорооны даргатай байгуулсан гэрээний дагуу бүх санхүүжилтийг хийсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.

Төсөл хэрэгжих үлдсэн хугацаанд төслийн удирдлагын батлагдсан зардлаас үлдсэн 590.0 мянган ам.долларыг цалин, ТХН-ийн үйл ажиллагааны зардалд зарцуулах болно. ТХН-ийн бүрэлдэхүүн хэрхэн өөрчлөгдөхөөс шалтгаалж тавилга, тоног төхөөрөмжийн бага хэмжээний зардал батлагдсан төсвийн хүрээнд гарах болно.

ҮАГ-ын тайлбар
2-ыг үзнэ үү.

2.2.2.3. Төслийн удирдах хороог нийт 3 удаа байгуулсан ба анх Сангийн сайдын 2011 оны 6 сарын 29-ний өдрийн 145 тоот тушаалаар батлахдаа Санхүүжилтийн хэлэлцээрт тусгасны дагуу Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан Сангийн яам, ЭБЭХЯ, ЗТБХБЯ /хуучнаар/, БОАЖЯ /хуучнаар/, ҮХШХ /хуучнаар/, ТӨХ болон УҮХ-ны төлөөллийг оруулан баталсан. 2012 оны 4

сарын 26-ны өдрийн 103 тоот тушаалаар ТУХ-г шинэчлэн батлахдаа мөн дээрх яам, холбогдох байгууллагуудаас төлөөллүүдийг бүрэлдэхүүнд оруулан баталсан болно. Сангийн сайдын 2013 оны 2 сарын 6-ны өдрийн 34 тоот тушаалаар шинэчлэн байгуулахдаа ҮХШХ татан буугдаж ЭЗХЯ болсноор тус яамнаас төлөөлөл оруулсан, БОНХЯ-н дээр ус хариуцсан хэлтэс шинээр байгуулагдсантай холбогдуулан тус яамнаас төлөөлөл орсон байгаа тул ҮҮХ-ноос төлөөлөл дахин оруулах шаардлагагүй гэж үзсэн болно.

Хавсралт 5. ТУХ-ны тушаалууд-3 ш

ҮАГ-ын тайлбар 3-ыг үзнэ үү.

2.4. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа 2011 оны 11 сарын 18-нд хүчин төгөлдөр болсон ч төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд оффис шинээр байгуулах, холбогдох мэдээлэл цуглуулах зэрэг ажлыг гүйцэтгэн, ТУХ-ны гишүүдтэй танилцаж, төслийн зорилго, үйл ажиллагааг танилцуулах зорилго бүхий анхны уулзалтыг 2011 оны 12 сарын 20-ны өдөр Сангийн яамны хурлын танхимд зохион байгуулан хамтран ажиллагч яам, байгууллагуудад хандан манай төслийн хүрээнд хэрэгжүүлэх нэн шаардлагатай төсөл, сургалтын саналуудыг ирүүлэх хүсэлтийг 2011 оны 12 сарын 23-ны өдрийн 2011/10 тоот албан бичгээр ТУХ-ны гишүүдэд 7 хоногийн хугацаатайгаар хүргүүлж, ирүүлсэн саналуудыг ТХН дээр нэгтгэж, боловсруулан 2012 оны 2 сарын 2-нд ТУХ-ны анхны хурлаар хэлэлцүүлж, улмаар 2 сарын 17-нд ТУХ-аар холбогдох төлөвлөгөөнүүдийг батлуулсан болно.

ҮАГ-ын тайлбар 4-ийг үзнэ үү.

2.5 ТХН нь үр ашиггүй зардал гаргасан гэсэн дүгнэлт гаргасан байна. ТХН-ийн оффисыг төсөл хэрэгжүүлж эхлэх үеийн оффисын түрээсийн зах зээлийн ханшаар тооцон Сангийн яамны Дэлхийн банкны асуудал хариуцсан мэргэжилтнээс холбогдох зөвшөөрөл авсны үндсэн дээр гэрээ байгуулж, гэрээний дагуу төлбөр тооцоог хийж ирсэн. Дүгнэлт гаргахын тулд харьцуулалт хийсэн төслийн нэгж түрээсийн гэрээгээ төсөл эхлэх үе буюу 5 жилийн өмнөх түрээсийн ханшаар хийсэн байгааг авч үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар 5-ыг үзнэ үү.

2.6 Төслийн Санхүүгийн удирдлагын мэргэжилтэн нь Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Төслийн удирдах хорооны даргатай 2011 оны 11 сарын 19-ний өдөр зөвлөх үйлчилгээний гэрээг 6 сарын туршилтын хугацаагаар байгуулсан бөгөөд Сангийн яамны 2012 оны 5 сарын 14 өдрийн 4/2620 дугаартай албан тоотой туршилтын хугацаан дахь гэрээний хэрэгжилтийг дүгнэсний үндсэн дээр төслийн санхүүгийн удирдлагын мэргэжилтэнтэй 2013 оны 5 сарын 20-ны өдрийг хүртэл нэг жилийн хугацаагаар гэрээ байгуулахыг зөвшөөрсөн байна.

Санхүүгийн баримтыг үдэж архивлаагүй гэж дүгнэсэн нь үндэслэлгүй дүгнэлт хэмээн Төслийн санхүүгийн удирдлагын мэргэжилтэн мэдэгдсэн байна. Учир нь 2012 оны санхүүгийн тайланд Далайван аудит ХХК-аар аудит хийлгэхээр шийдвэр гарсан байсан бөгөөд баримтыг аудит бүрэн хийгдэж дууссаны дараа үдэж, архивлахаар бэлдсэн байсан болно.

ҮАГ-ын тайлбар 6-г үзнэ үү.

2.7,2.8. Сангийн сайдын 2011 оны 4 сарын 14-ний өдрийн 86 дугаар журмын 3.1.12-т заасны дагуу батлагдсан төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлуудыг төслийн захиралд тухай бүрд нь тайлагнаж, дотоод томилолтын тайланг тухайн төслийн хүрээнд сонгогдсон бие даасан зөвлөхүүд болон ажлын хэсгүүдэд тайлагнаж байсан болно.

ҮАГ-ын тайлбар
7-г үзнэ үү.

3.2. Төмөр замын газрын дэд дарга Л.Пүрэвбаатар болон техник, технологийн хэлтсийн дарга Д.Мандахбаяр нар нь тус төслийн дэд төслүүд болох Төмөр замын төслүүдийн ажлын хэсгийн дарга болон гишүүнээр ажиллаж байсан ба тус төслийн хүрээнд холбогдох яам, агентлагуудын ажиллагсдын болон ажлын хэсгийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх зорилтын хүрээнд дурьдсан сургалтуудад хамрагдсан болно.

Хавсралт 6. Ажлын хэсгийн тушаал

ҮАГ-ын тайлбар
8-ыг үзнэ үү.

3.4, 3.5 Компанийн засаглалыг сайжруулах сэдэвт сургалт нь Төслийн санхүүжилтийн хэлэлцээрийн Хуваарь 1-ийн Хэсэг 2a(iii)-т "Төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэглэх, хөрөнгө оруулагчидтай хамтарч ажиллах талаар Засгийн газрын албан тушаалтнууд болон бизнес эрхлэгчдийн мэдлэгийг дэмжих үүднээс бага хурал зохион байгуулах, харилцааны бусад хэрэгслүүдийг ашиглах" гэж заасны дагуу Төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлж эхэлж байгаатай холбогдуулан хувийн компаниудын төлөөллүүдийн чадавхийг бэхжүүлэх үндсэн дээр зохион байгуулагдсан сургалт болсон.

ҮАГ-ын тайлбар
9-ийг үзнэ үү.

3.11. Тус төслийн хүрээнд дээрх 6 дэд төслийн ТЭЗҮ, ажлын даалгавар боловсруулахаар анх шийдвэрлэсэн. "Төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан "Хөөт-Бичигт" чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл эзэмшигч "Монголын төмөр зам" ТӨХК "Шинэ төмөр зам" төслийн хүрээнд боловсруулахаар, "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 3 дахь үе шатанд шинээр барих төмөр замын чиглэлийг Зам, тээврийн яам хариуцан тодорхойлохоор ажиллаж байгаа болон манай төслийн хүрээнд хийгдсэн ажил, тайлан, тооцоог хүргүүлэхийг хүссэнийг тус яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ё.Манлайбаярын 2012 оны 12 сарын 12-ны өдрийн 8/2185 тоот албан бичгээр мэдэгдсэнийг үндэслэн манай төслийн үйл ажиллагаанаас дээрх 2 төслийг хасч, боловсруулсан ажлын даалгавар болон холбогдох тайланг тус яаманд хүргүүлсэн болно. Одоогийн байдлаар тус төслийн хүрээнд дараах 3 төслүүдийн хоёрдахь шатны ажлууд хийгдэж байна. Үүнд:

- Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан сан байгуулах төслийн ТЭЗҮ боловсруулах
- Дархан-Сэлэнгийн төвийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт барьж байгуулах төслийн ТЭЗҮ боловсруулах
- Шүрэнгийн УЦС-ын төслийн ТЭЗҮ боловсруулах

Хавсралт 7. Зам, тээврийн яамнаас ирүүлсэн албан бичиг.

**АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТЭД ҮНДЭСЛЭН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ЗӨВЛӨМЖИД ӨГӨХ САНАЛ**

ҮАГ-ын тайлбар
10-ыг үзнэ үү.

- Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай Сангийн сайдын тушаалыг боловсруулан баталж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын төлөөллийг бүрэлдэхүүнд нэмж оролцуулах
- Төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, явцад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллах

-оОо-

Сангийн яамнаас ирүүлсэн саналд ҮАГ-аас өгөх тайлбар:

ҮАГ-ын тайлбар 1. Төслийн удирдлагын зардал гэснийг төхөөрөмжийн худалдан авалтыг оролцуулан тооцсноор гэж залруулав.

ҮАГ-ын тайлбар 2. Холбогдох өөрчлөлтийг оруулав.

ҮАГ-ын тайлбар 3. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 4. Өөрчлөлт оруулах шаардлагагүй

ҮАГ-ын тайлбар 5. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 6. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 7. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 8. Холбогдох өөрчлөлтийг оруулав.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Сангийн сайд Ч.Улаанд

- ✚ Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын эрх бүхий албан тушаалтнуудыг оруулах,
- ✚ Төсөл хэрэгжүүлэх нэгжийг Монгол Улсын Засгийн газар, ОУХА хооронд байгуулсан гэрээ, Сангийн сайдын 2011 оны 86 дугаар журмын дагуу байгуулж, ажиллуулах,
- ✚ Төсөл, Төслийн удирдах хороо, хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг сайжруулж, хяналтыг чангатган үр дүнг тогтмол тооцож, холбогдох арга хэмжээг авч байх,
- ✚ Төслийн үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулан нэн тэргүүний, зайлшгүй шаардлагатай дэд төслүүдийг сонгон шалгаруулж санхүүжүүлэх,
- ✚ Харилцах дансны хүүгийн орлогыг төсөвт төвлөрүүлэн, тушаал шийдвэргүй зарцуулсан холбогдох этгээдэд арга хэмжээ авах,



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслүүдийн үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн Яаманд хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2014 оны 03 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал (Б.Баттуяа)-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

